



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 09 сарын 09 -ны өдөр

Дугаар 1/90

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дах заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9.1.4 тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлын үед халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал хангах ажлын хүрээнд худалдан авах ариутгал халдваргүйтгэлийн бодис, хөвөн бамбарын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн байгууллагуудад худалдан авсан ариутгал халдваргүйтгэлийн бодис, хөвөн бамбарын чанар, зарцуулалтад хяналт тавихыг Эмийн бодлогын хэрэгжилт, чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн /О.Анхбаяр/-т, хүлээн авч, анхан шатны бүртгэлийг бүртгэлжүүлэхийг баримтжуулахыг нярав /Б.Алтанзагас/-д үүрэг болгосугай.

3. Холбогдох 1.601.000 /нэг сая зургаан зуун нэг мянга/-н төгрөгийн зардлыг Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авах зардлаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодогч /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилт болон гэрээний хяналт тавьж ажиллахыг ХШҮДАХ мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ

ХУДАЛДАН АВАХ АРИУТГАЛ ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН БОДИС,

ХӨВӨН БАМБАРЫН ЖАГСААЛТ

№	Эмнэлгийн хэрэгслийн нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Гар ариутгагч спрей	30	2,500	75,000
2	Аниос гель 500мл	10	15 000	150,000
3	Саванду 500мл	10	11,000	110,000
4	Саван 5л /phago Derm Sensitive 5L/	1	60,000	60,000
5	Аниос гель 5л	2	110,000	220,000
6	Хөвөн бамбар	34	22,000	748,000
7	Хөвөн бамбар /тагтай/	850	280	238,000
	Нийт			1,601,000

Төлөвлөлт гаргасан ЭБХЧАБЗХХМ  О.Анхбаяр

Хянасан: ЭМГ-ын нягтлан бодогч

 Н.Чулуун-Эрдэнэ